



ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР
ИРГЭНИЙ НИСЭХИЙН
ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ДАРГЫН
ТУШААЛ

2021 оны 09 сарын 02 өдөр

Дугаар А/323

Улаанбаатар хот

Шинжилгээ авах багийн бүрэлдэхүүнийг
шинэчлэн томилох тухай

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2.2, Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2.1, Монгол Улсын Шадар Сайдын 2020 оны “Стратеги, төлөвлөгөө батлах тухай” 26 дугаар тушаалын 3.9.4, Иргэний нисэхийн үндэсний төвийн дүрмийн 4.2.7 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Иргэний нисэхийн үндэсний төвийн зохион байгуулалтын бүтэц шинэчлэн батлагдсантай холбогдуулан Коронавируст халдвар /ковид-19/-ын онцгой нөхцөл байдал үүссэн үед халдвар голомтлон тархахаас сэргийлэх зорилгоор шаардлагатай ажилтнуудаас шинжилгээ авах багийг шинэчлэн дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсугай. Үүнд:

Багийн дарга:

Т.Хулан

Эрүүл мэнд, спортын цогцолборын дарга

Нарийн бичгийн дарга:

Д.Ариунзаяа

Эрүүл мэнд, спортын цогцолборын бичиг хэрэг, албан хэрэг хөтлөлтийн мэргэжилтэн

Гишүүд:

Х.Эрдэнэ

Эрүүл мэнд, спортын цогцолборын их эмч

Б.Батмагнай

Эрүүл мэнд, спортын цогцолборын их эмч

Б.Дэлгэрмаа

Эрүүл мэнд, спортын цогцолборын их эмч

Ю.Одгэрэл

Эрүүл мэнд, спортын цогцолборын их эмч

Э.Мөнх-Эрдэнэ

Эрүүл мэнд, спортын цогцолборын их эмч

С.Чинзориг

Аэродром, барилга байгууламжийн ашиглалтын албаны Аж ахуй, хангамжийн хэсгийн ахлах мэргэжилтэн

2. Коронавируст халдвар /ковид-19/ илрүүлэх PCR болон түргэвчилсэн шинжилгээ авах ажлыг зохион байгуулах, зохих бэлтгэлийг хангах, холбогдох түр заавар, төсөв, төлөвлөгөө боловсруулж, батлуулах, мэргэжлийн байгууллагаас сургалт, дадлага авах, онцгой нөхцөл байдал үүссэн үед ажилтнуудаас шинжилгээг шуурхай авах, шинжлүүлэх ажлыг зохион байгуулахыг багийн дарга (Т.Хулан)-д, шинжилгээ авах байраар хангаж ажиллахыг Захиргаа, хүний нөөцийн газрын дарга (Р.Амарбаясгалан)-д тус тус даалгасугай.

3. Шинжилгээ авах багийн үйл ажиллагаатай холбогдон гарах зардлыг төсөвлөн зарцуулахыг Санхүү, эдийн засаг төлөвлөлтийн газар (Б.Батхишиг)-т зөвшөөрсүгэй.

2.

4. Энэ тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Иргэний нисэхийн үндэсний төвийн Гамшгаас хамгаалах штаб (П.Гантөгс)-т үүрэг болгосугай.

5. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Иргэний нисэхийн үндэсний төвийн даргын 2021 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн “Шинжилгээ авах баг томилох тухай” А/24 дүгээр тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



П.МӨНХЖАРГАЛ